

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

И Монгол академи УТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СНАГ-2024/51/НА-СТА-ТӨА

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2024 он	Санхүү-нийцлийн газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: П.Чанцалдулам Утас: 261628 Цахим хаяг: chantsaldulamp@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Мөнхжин Утас: 261740 Цахим хаяг: munkhjind@audit.gov.mn Аудитор: Д.Болормаа Утас: 267140 Цахим хаяг: bolormaad@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2024.02.23 № 07/2024

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу И Монгол академи УТУГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

И Монгол академи УТУГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

И Монгол академи УТУГ нь тайлант онд төрийн үйлчилгээний нэгдсэн системийн /E-mongolia/ 3.0 хувилбар, хуулийн этгээдэд үйлчилгээ үзүүлэх e-Business систем, оюутнуудад зориулсан e-students, хүүхдийн аюулгүй байдалд хяналт тавих E-kids зэрэг системүүдийг хөгжүүлж, хэрэглээнд нэвтрүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Засгийн газрын 2023 оны 100, 233 дугаар тогтоолоор Шинэ сэргэлтийн бодлого, цахим аймаг бодлогын зөвлөмжийн хүрээнд 122 API сервисийг хөгжүүлэн ХУР системд нийлүүлж, Төрийн үйлчилгээний нэгдсэн системд 363 үйлчилгээг шинээр нэвтрүүлж, орон нутаг дах төрийн үйлчилгээг цахимжуулах, нээлттэй өгөгдлийг нэмэгдүүлэх, цахим ур чадварыг сайжруулахад 70,000.0 мянган төгрөгийн зардал гарсан байна.

Бусад асуудлын хэсэг

И Монгол академи УТУГ-ын 2023 онд хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоон хэмжээний үзүүлэлтэд тусгасан 7 зорилтын хүрээнд хэрэгжүүлсэн 83 арга хэмжээнээс 81 арга хэмжээ зорилтот түвшиндээ бүрэн хүрч, гүйцэтгэл 99.7 хувьтай байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>93,367,295.26</u>	<u>111,658,835.87</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	16,052,483.50	27,015,212.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	16,052,483.50	27,015,212.00
3121	Төгрөг	16,052,483.50	27,015,212.00
31211	Төрийн сангийн харилцах	16,052,483.50	27,015,212.00
34	УРЬДЧИЛГАА	-	4,534,583.00
34600	Урьдчилж гарсан зардал	-	4,534,583.00
35	БАРАА МАТЕРИАЛ	77,314,811.76	80,109,040.87
354	Хангамжийн материал	77,314,811.76	80,109,040.87
35410	Бичиг хэргийн материал	4,313,807.12	2,690,476.16
35420	Аж ахуйн материал	2,905,139.25	2,799,690.00
35440	Түлш, шатах тослох материал	67,150.00	2,015,963.00
35460	Хүнсний материал	801,570.00	-
35470	Бусад хангамжийн материал	69,227,145.39	72,602,911.71
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>551,338,110.04</u>	<u>789,660,675.84</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	551,338,110.04	789,660,675.84
392	Биет хөрөнгө	540,164,266.04	812,672,564.59
39203	Авто-тээврийн хэрэгсэл	-	33,800,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-	(14,570,000.02)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	583,660,309.50	916,613,722.50
39206	Хуримтлагдсан элэгдэл	(135,149,726.03)	(263,305,878.94)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	84,427,500.00	145,468,500.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(4,272,021.03)	(13,997,613.99)
39214	Бусад үндсэн хөрөнгө	13,209,230.00	13,209,230.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(1,711,026.40)	(4,545,394.96)
393	Биет бус хөрөнгө	11,173,844.00	(23,011,888.75)
39301	Програм хангамж	4,800,000.00	7,000,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(400,000.00)	(5,203,333.37)
39303	Бусад биет бус хөрөнгө	31,595,376.00	31,595,376.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(24,821,532.00)	(56,403,931.38)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>644,705,405.30</u>	<u>901,319,511.71</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>16,052,483.50</u>	<u>27,581,187.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	16,052,483.50	27,581,187.00
413	Өглөг	16,052,483.50	27,581,187.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	565,975.00
4136	Бусад өглөг	16,052,483.50	27,015,212.00
41361	Байгууллагад төлөх өглөг	16,052,483.50	27,015,212.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>628,652,921.80</u>	<u>873,738,324.71</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	628,652,921.80	873,738,324.71
512	Хуримтлагдсан үр дүн	628,652,921.80	873,738,324.71
51210	Өмнөх үеийн үр дүн	628,652,921.80	628,652,921.80
51220	Тайлант үеийн үр дүн	-	245,085,402.91
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>644,705,405.30</u>	<u>901,319,511.71</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	7,316,202,598.50	7,698,094,603.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	57,543,798.50	62,134,703.00
120	Нийтлэг татварын бус орлого	57,533,798.50	62,134,703.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	57,533,798.50	62,134,703.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	41,091,889.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	420,000.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	57,113,798.50	21,042,814.00
122	Тусламжийн орлого	10,000.00	-
122001	Хандив тусламж /дотоод/	10,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	7,258,658,800.00	7,635,959,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	7,258,658,800.00	7,635,959,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	7,258,658,800.00	7,635,959,900.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	6,687,549,676.70	7,453,009,200.09
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,687,549,676.70	7,453,009,200.09
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,259,903,484.31	6,974,146,496.12
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,980,982,542.86	4,770,020,008.17
210101	Үндсэн цалин	1,722,549,957.99	3,745,024,240.34
210102	Нэмэгдэл	50,427,775.27	52,762,040.56
210103	Унаа хоолны хөнгөлөлт	94,020,311.42	266,311,000.00
210104	Урамшуулал	113,984,498.18	705,922,727.27
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	247,257,632.88	596,746,317.81
210201	Тэтгэврийн даатгал	168,244,098.50	407,354,047.34
210202	Тэтгэмжийн даатгал	19,793,423.37	47,924,005.55
210203	ҮОМШӨ-ний даатгал	15,830,148.68	38,216,003.50
210204	Ажилгүйдлийн даатгал	3,873,370.83	9,350,788.76
210205	Эрүүл мэндийн даатгал	39,516,591.50	93,901,472.66
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	270,752,634.01	374,671,507.97
210301	Гэрэл, цахилгаан	16,484,022.01	2,743,332.77
210302	Түлш, халаалт	-	1,728,874.20
210304	Байрны түрээс	254,268,612.00	370,199,301.00
2104	Хангамж, бараа материалын зардал	116,290,112.24	135,133,317.00
210401	Бичиг хэрэг	42,356,811.88	7,867,830.96
210402	Тээвэр, шатахуун	7,584,000.00	6,174,001.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	32,443,130.00	39,293,859.11
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	5,300,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,944,000.00	65,731,853.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	31,962,170.36	10,765,772.93
2105	Нормативт зардал	2,520,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,520,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,925,800.00	287,696,501.00
210604	Урсгал засвар	1,925,800.00	287,696,501.00
2107	Томилолт, зочны зардал	43,796,900.00	46,227,920.20
210701	Гадаад албан томилолт	-	17,542,220.20
210702	Дотоод албан томилолт	43,796,900.00	28,685,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	533,834,161.36	435,599,996.77

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	533,834,161.36	341,852,548.80
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	93,747,447.97
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	62,543,700.96	328,050,927.20
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,950,000.00	105,074,080.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	44,185,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	57,593,700.96	178,791,847.20
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,427,646,192.39	478,862,703.97
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,900,000.00	17,320,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,900,000.00	17,320,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	461,542,703.97
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	461,542,703.97
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,422,746,192.39	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	628,652,921.80	245,085,402.91
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	628,652,921.80	245,085,402.91

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	7,275,131,283.50	7,691,996,401.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	16,472,483.50	56,036,501.00
120	Нийтлэг татварын бус орлого	16,472,483.50	56,036,501.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	16,472,483.50	56,036,501.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	16,052,483.50	55,711,569.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	420,000.00	324,932.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	7,258,658,800.00	7,635,959,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	7,258,658,800.00	7,635,959,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	7,258,658,800.00	7,635,959,900.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	6,707,260,787.50	7,284,839,259.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,707,260,787.50	7,284,839,259.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,279,614,595.11	6,805,651,623.53
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,980,982,542.86	4,769,454,113.14
210101	Үндсэн цалин	1,722,549,957.99	3,748,830,630.21
210102	Нэмэгдэл	50,427,775.27	83,882,181.54
210103	Унаа хоолны хөнгөлөлт	94,020,311.42	264,243,961.30
210104	Урамшуулал	113,984,498.18	672,497,340.09
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	247,257,632.88	596,746,237.84
210201	Тэтгэврийн даатгал	168,244,098.50	407,354,046.91
210202	Тэтгэмжийн даатгал	19,793,423.37	47,924,005.32
210203	ҮОМШӨ-ний даатгал	15,830,148.68	38,215,924.79
210204	Ажилгүйдлийн даатгал	3,873,370.83	9,350,788.53
210205	Эрүүл мэндийн даатгал	39,516,591.50	93,901,472.29
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	270,752,634.01	374,671,507.97
210301	Гэрэл, цахилгаан	16,484,022.01	2,743,332.77
210302	Түлш, халаалт	-	1,728,874.20
210304	Байрны түрээс	254,268,612.00	370,199,301.00
2104	Хангамж, бараа материалын зардал	75,692,021.00	91,073,815.11
210401	Бичиг хэрэг	13,875,130.00	8,206,500.00
210402	Тээвэр, шатахуун	2,688,150.00	5,943,500.00

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	32,443,130.00	39,293,859.11
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,581,149.00	5,300,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	25,104,462.00	32,329,956.00
2105	Нормативт зардал	3,250,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,250,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	36,647,180.00	307,933,869.50
210601	Багаж, техник, хэрэгсэл	31,655,850.00	16,054,968.50
210604	Урсгал засвар	4,991,330.00	291,878,901.00
2107	Томилолт, зочны зардал	48,836,900.00	46,784,420.20
210701	Гадаад албан томилолт	-	17,542,220.20
210702	Дотоод албан томилолт	48,836,900.00	29,242,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	584,850,161.36	440,178,579.77
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	584,850,161.36	341,852,548.80
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	98,326,030.97
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	31,345,523.00	178,809,080.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	31,345,523.00	133,224,080.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	45,585,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,427,646,192.39	479,187,635.97
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,900,000.00	17,320,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,900,000.00	17,320,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,422,746,192.39	461,867,635.97
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,422,746,192.39	461,867,635.97
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>567,870,496.00</u>	<u>407,157,141.50</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	<u>551,818,012.50</u>	<u>396,194,413.00</u>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	<u>551,818,012.50</u>	<u>396,194,413.00</u>
2200	Дотоод эх үүсвэрээр	<u>551,818,012.50</u>	<u>396,194,413.00</u>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	551,818,012.50	396,194,413.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(551,818,012.50)</u>	<u>(396,194,413.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	16,052,483.50	10,962,728.50
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	16,052,483.50
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	16,052,483.50	27,015,212.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	-	-	-	-
Өмнөх оны үр дүн	-	-	628,652,921.80	628,652,921.80
2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	-	-	628,652,921.80	628,652,921.80
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	628,652,921.80	628,652,921.80
Тайлант үеийн үр дүн	-	-	245,085,402.91	245,085,402.91
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	873,738,324.71	873,738,324.71

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	7,665,976,500.00	7,256,600,974.03	409,375,525.97	94.66
УРСГАЛ ЗАРДАЛ	7,665,976,500.00	7,256,600,974.03	409,375,525.97	94.66
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,623,925,900.00	7,198,189,085.03	425,736,814.97	94.42
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,898,130,000.00	4,769,454,113.14	128,675,886.86	97.37
Үндсэн цалин	4,353,970,000.00	3,748,830,630.21	605,139,369.79	86.1
Нэмэгдэл	544,160,000.00	83,882,181.54	460,277,818.46	15.41
Унаа хоолны хөнгөлөлт		264,243,961.30	(264,243,961.30)	-
Урамшуулал		672,497,340.09	(672,497,340.09)	-
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	612,266,300.00	596,746,237.84	15,520,062.16	97.47
Тэтгэврийн даатгал	416,341,100.00	407,354,046.91	8,987,053.09	97.84
Тэтгэмжийн даатгал	48,981,300.00	47,924,005.32	1,057,294.68	97.84
ҮОМШӨ-ний даатгал	39,185,000.00	38,215,924.79	969,075.21	97.53
Ажилгүйдлийн даатгал	9,796,300.00	9,350,788.53	445,511.47	95.45
Эрүүл мэндийн даатгал	97,962,600.00	93,901,472.29	4,061,127.71	95.85
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	476,700,000.00	374,671,507.97	102,028,492.03	78.6
Гэрэл, цахилгаан	16,500,000.00	2,743,332.77	13,756,667.23	16.63
Түлш, халаалт	7,800,000.00	1,728,874.20	6,071,125.80	22.17
Цэвэр, бохир ус	6,000,000.00		6,000,000.00	
Байрны түрээс	446,400,000.00	370,199,301.00	76,200,699.00	82.93
Хангамж, бараа материалын зардал	116,805,700.00	91,663,715.11	25,141,984.89	78.48
Бичиг хэрэг	18,000,000.00	8,206,500.00	9,793,500.00	45.59
Тээвэр, шатахуун	6,000,000.00	5,943,500.00	56,500.00	99.06
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	54,000,000.00	39,293,859.11	14,706,140.89	72.77
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	6,000,000.00	5,300,000.00	700,000.00	88.33
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	32,805,700.00	32,919,856.00	(114,156.00)	100.35
Нормативт зардал	7,000,000.00	-	7,000,000.00	0.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл	7,000,000.00	-	7,000,000.00	0.00
Эд хогшил, урсгал засварын зардал	784,263,000.00	697,681,431.00	86,581,569.00	88.96
Багаж, техник, хэрэгсэл	458,217,100.00	390,802,530.00	67,414,570.00	85.29
Тавилга	15,000,000.00	15,000,000.00	-	100.00
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	5,000,000.00	-	5,000,000.00	0.00
Урсгал засвар	306,045,900.00	291,878,901.00	14,166,999.00	95.37
Томилолт, зочны зардал	55,573,100.00	46,784,420.20	8,788,679.80	84.19
Гадаад албан томилолт	19,500,000.00	17,542,220.20	1,957,779.80	89.96
Дотоод албан томилолт	36,073,100.00	29,242,200.00	6,830,900.00	81.06
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	470,700,800.00	442,378,579.77	28,322,220.23	93.98
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	349,700,800.00	341,852,548.80	7,848,251.20	97.76
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	121,000,000.00	100,526,030.97	20,473,969.03	83.08
Бараа үйлчилгээний бусад зардал	202,487,000.00	178,809,080.00	23,677,920.00	88.31
Бараа үйлчилгээний бусад зардал	152,487,000.00	133,224,080.00	19,262,920.00	87.37
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	50,000,000.00	45,585,000.00	4,415,000.00	91.17

УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	42,050,600.00	58,411,889.00	(16,361,289.00)	138.91
Бусад урсгал шилжүүлэг	42,050,600.00	17,320,000.00	24,730,600.00	41.19
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	42,050,600.00	17,320,000.00	24,730,600.00	41.19
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	41,091,889.00	(41,091,889.00)	-
Төвлөрүүлэх шилжүүлэг	-	41,091,889.00	(41,091,889.00)	-
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	7,651,925,900.00	7,256,600,974.03	395,324,925.97	94.83
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	7,651,925,900.00	7,215,509,085.03	436,416,814.97	94.30
Улсын төсвөөс санхүүжих	7,651,925,900.00	7,215,509,085.03	436,416,814.97	94.30
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	41,091,889.00	(41,091,889.00)	-
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	41,091,889.00	(41,091,889.00)	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	16,052,483.50	(16,052,483.50)	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	27,015,212.00	(27,015,212.00)	-
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	1	100.00
АЖИЛЛАГСАДЫН ТОО	112	112	112	100.00
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	125	125	125	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	41,091,889.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	41,091,889.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	41,091,889.00
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	-	41,091,889.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	41,091,889.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	41,091,889.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	41,091,889.00

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 84,251.7 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 84,251.7 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тайлант оны төсөвт батлагдаагүй 80,412.7 мянган төгрөгийн урамшууллыг цалингийн сангаас олгосон байна.	1	80,412.7					1	80,412.7				
Багаж техник хэрэгслийн зардлаас хөрөнгийн шинж чанартай тавилга эд хогшил бэлтгэсэн байна.	1	1,839.0					1	1,839.0				
Анхан шатны бүрдэл дутуу 2,000.0 мянган төгрөгийн ажил гүйлгээг санхүүжүүлсэн байна.	1	2,000.0					1	2,000.0				
Дүн	3	84,251.7					3	84,251.7				

АДБООУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар шилэн дансны цахим хуудаст тайлант онд мэдээлбэл зохих 166 мэдээллээс 3 мэдээллийг хугацаа хоцроон мэдээлсэн зөрчил илэрсэнд зөрчлийг арилгах зөвлөмж өгсөн.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
Шилэн дансны цахим хуудаст тайлант онд мэдээлэх 3 мэдээллийг хугацаа хоцроон мэдээлсэн байна.	1	-			1	-
Нийт дүн	1	-			1	-